



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
"НАРАН" СУРГУУЛЬ

# ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГАДУУРХАЛТЫН АСУУДАЛ

ᠠᠨᠠᠷᠠᠨ ᠰᠣᠷᠭᠠᠭᠤᠯᠤᠰ

## Илтгэл

10А О.Бадамсугай 89719677

10А Т.Ану-үжин

9А А.Учрал

## Удирдагч багш

Б.Билгүүдэй 94113932 [bilguudei0524@gmail.com](mailto:bilguudei0524@gmail.com)

Улаанбаатар хот  
2023 он

### Үндэслэл

Бидний амьдарч байгаа энэхүү цаг хугацааны гол түлхүүр нь цахим хэрэглээ болсон гэж хэлэхэд хэлсдэхгүй. Цахим орчин өргөжихийн хэрээр хэрэглэгчдийн дийлэнх хувийг өсвөр залуус эзлэх хандлагатай байгааг сүүлийн жилүүдээс харж болно. Харин өсвөр залуу насныханд цахим орчин тэлснээр энэ орчинд нийгэм дагах асуудлууд тулгарч эхэлж байгаа юм. Эдгээр асуудлуудын салаа эш нь гадуурхалт мөн. Хүн төрөлхтний нийгмийн бүхий л үед шийдэгдээгүй томоохон асуудал болох гадуурхалт нь нийгмээс сошиал орчинд шилжин орж ирсэн. Нийгэмд хараахан хөл тавиагүй байгаа бага залуу насныхны цахим орчны аюулгүй байдал болоод хувь хүний эрхийн талаарх мэдээлэл хомс байгаатай энэ нь шууд холбоотой. Тэгвэл бид сурагчид дунд байх цахим орчны гадуурхалтын талаар судалгаа хийж, дижитал сүлжээн дэхь, зөв зохистой соёлыг тодорхойлохыг эрэлхийлэв.

**Судалгааны зорилго:** Цахим орчинд сурагчдын эрх хэрхэн зөрчигдөж, гадуурхалт хэрхэн хөл авч байгааг онол, практикын аргаар судалж, сурагчдын цахим хэрэглээ ямар түвшинд байгааг, зөв зохистой цахим хэрэглээний жишигт хүрэхэд ямар асуудал үүсч байгааг тодорхойлохыг зорилго болгоно.

**Дээрх зорилгоос дараах зорилтууд дэвшүүлж байна.** Үүнд:

1. Цахим орчин дахь зөв зохистой хэрэглээг тодорхойлох.
2. Бага залуу насныхны цахим орчны тухай ойлголтыг тодорхойлох.
3. Сурагчдаас цахим орчны зохистой байдлын талаар судалгаа авч, анализ хийх.
4. Судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулж логик дүгнэлт гаргах
5. Судалгаанд тулгуурлан цахим орчны ашиглалтыг гадуурхалтгүйгээр зөв бүрдүүлэх арга замыг тодорхойлох.

**Судалгааны хамрах хүрээ:** Ерөнхий боловсролын Наран сургуулийн сурагчдын хүрээнд,

**Нийгмийн сүлжээ:**, Фейсбүүк платформ.


**Тулгуур ухагдахуун:** Дижитал шилжилт, Цахим хэрэглээ, Сошиал орчин, Цахим орчны гадуурхалтын асуудал, Фейсбүүк платформ

## Онолын хэсэг

Цахим орчин гэдэг нь дэлхий нийтийг хамарсан, бүхий л интернэт төхөөрөмжийг холбодог асар том сүлжээний хэрэгсэл бөгөөд нэг талаар хүн төрөлхтөнд томоохон мэдээллийн сан болж өгдөг интернэт орчин юм. Интернэт нь хүн төрөлхтөний түүхэн томоохон ололт амжилтын нэгд зүй ёсоор багтаад зогсохгүй, 1969 онд интернэт зохион бүтээгдснээс хойш тасралтгүй хөгжсөөр өнөө үед ирсэн ажээ. Энэхүү сүлжээ нь 1990 онд дэлхий нийтэд танигдснаар хүний бүхий л ажил хөнгөвчлөгдөж, бидний амьдрал илүү тогтвортой болоод байна. Өнөө үед интернэт, цахим сүлжээ нь хүмүүсийн хэрэгцээний эхэнд гарцаагүй бичигдэх болсон нь бидний амьдралтай шууд холбоотой болсныг илтгэнэ. (<https://criminal.police.gov.mn/a/276/>) Энэ холбоог ашиглан хэсэгчилсэн аль эсвэл нэгдсэн холболт ажиглах нь ихэсч, компьютерийн сүлжээ анхлан үүсчээ. Компьютерийн сүлжээ гэдэг нь компьютеруудыг хооронд нь техник хэрэгсэл болон программын тусламжтайгаар холбосон системийг хэлэх ба Монгол оронд анх 1994 онд “Мэдээллийн харилцаа” ББХК интернет сүлжээг нэвтрүүлсэн байдаг. ([www.1212.mn](http://www.1212.mn)) 1996 оны нэгдүгээр сард Монгол улс интернэтэд холбогдож байгаагаа батлан зарласан бөгөөд нийт 10 компьютер дээр дэлхийн алдартай сувагуудыг гаргаж байв. 2022 оны дөрөвдүгээр сарын байдлаар Монгол улсад давхардсан тоогоор нийт интернэт хэрэглэгчдийн тоо 4,187,600 хүрсэн байна. Харин энэхүү тоо баримт 2021 оны дөрөвдүгээр сарын байдлаар 4,137,300 , 2020 оны дөрөвдүгээр сарын байдлаар 3,902,700 байснаас харвал улсын интернэт хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байгаа аж. ([www.1212.mn](http://www.1212.mn))

Монгол улсын орчин цагийн хэрэглээнээс харвал интернэт хөгжихийн зэрэгцээ залуучуудын дунд цахим сүлжээ ихээхэн нэрд гарч байна. (<https://criminal.police.gov.mn/a/89>) Дижитал орчин эрчтэй газар авч байгаа нь бага залуу насныхны сонирхолыг төрүүлж, цаашлаад энэ нь хараа хяналтгүй цахим сүлжээний ашиглалт болон хувирч байгаа болно. (<https://gia.gov.mn/12/item/709>) Цахим сүлжээнд нийгмийн талаарх бүрэн ойлголтгүй хүүхэд хөл тавих нь аюулгүй байдлийн хувьд болоод эрх үүргийн хувьд хохиролтой. Бага насны хүүхдүүд цахим платформууд болох *facebook*, *Instagram*, *tiktok* дээр ихээхэн идэвхи үзүүлж байгаа бөгөөд үүнээс үүдэж тухайн платформууд дээр ялгаварлан гадуурхалт, цахим дээрэлхэлт ихээр явагдаж байдаг. Тиймээс бид эрчийг авч буй энэ орчинг зөвөөр хөгжүүлэх нь зүйтэй. Тэгэхийн тулд юун түрүүнд бага залуу насныханд цахим орчны зөв зохистой хэрэглээг зааж, цахим сүлжээн дэхь аюулаас сэргийлэх боомжоор хангах хэрэгтэй. .

Энэ чиглэлээр дагнан судалгаа хийдэг “NapoleonCat”-ын 2020 оны нэгдүгээр сард хийсэн судалгаагаар Монгол улсад Facebook нийгмийн сүлжээг хэрэглэгчдийн тоо 2 сая 236 мянгад хүрч үүнээс 36 хувийг нь 13-24 насны залуучууд хэрэглэж буй талаарх судалгааг хийжээ.



Хүснэгт №1 Монгол улсын Facebook хэрэглэгчдийн тоо

Хууль эрх зүйн үндэслэл: УИХ-аас “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2022 оны 5 сарын нэгнээс мөрдөж эхэлсэн нь иргэдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангаж өгөх гол үндэс болж байна. Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагаас 2 жил тутам гаргадаг “Кибер аюулгүй байдлын индекс”-ээр Монгол Улс 2020 оны байдлаар 193 орноос 120 дугаар байрыг эзэлсэн бөгөөд үүнээс үзвэл Монгол улсын кибер аюулгүй

байдал нь хангалттай хэмжээнд биш. “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-н гуравдугаар бүлгийн 18дугаар зүйлд заасан иргэний хүлээх үүрэг, эхний бүлэгт заасан зарчмууд нь Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх үндсэн нөхцөл болно. Хуулийн эдгээр зарчмуудын хэрэгжилтийг хангахад нэн түрүүнд журам, аргачлал, шаардлагыг боловсруулан батлуулах, иргэдэд зохистой мэдлэг түгээх, олон нийт болод хүний нөөцийг чадваржуулах, ойлголт түгээх асуудлууд шийдэгдэх шаардлагатай байна. ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn))

Цахим орчин дахь гадуурхалтанд бид дараах ойлголтуудыг багтаан дэвшүүлж байна. Эдгээр нь:

1. Бусдын нэр төрд халдсан үйл ажиллагаа цахим орчинд явуулах (Зохисгүй үг ашиглаж бусдыг доромжлох)
2. Худал хуурмаг, сөрөг мэдээг хэн нэгэнрүү чиглүүлэн цахим орчинд тараах (Батлагдаагүй цуу яриа, мэдээг тараах)
3. Бусдын хувийн нууцлалд халдсан үйлдэл цахим орчинд гаргах (Бусдын хувийн мэдээллийг санаатай ба санаандгүй байдлаар тараах)
4. Бусдыг ямар нэг байдлаар хохироох санаатай болоод санаандгүй үйлдэл цахим орчинд гаргах (Биед эсвэл сэтгэлзүйд хохирол учруулах)
5. Цахим орчинд бусдад дайсагнан сүрдүүлэх (Сүрдүүлсэн өнгө аястай үйлдэл гаргах)

## TYPES OF BULLYING



**Verbal Bullying**



**Physical Bullying**



**Cyber Bullying**



**Social Bullying**


Зураг №1 Дээрэлхэт гадуурхалтын 4 төрөл

### Үндсэн хэсэг

Энэхүү судалгаандаа Нийслэлийн Ерөнхий боловсролын Наран сургуулийн дунд ангийн сурагчдын цахим орчмын тухай ойлголт тэр дундаа Фейсбүүк платформын хэрэглээ, гадуурхалтын асуудлыг судалсан нь судалгааны хязгаарлагдмал тал болж байна. Судалгааг үндсэн 2 хэсэгтэйгээр зохион байгуулсан бөгөөд эхний хэсэгтээ сурагчдын цахим орчны зохистой хэрэглээ, гадуурхалтын талаарх ойлголт, насны хандлага зэргийг тогтоосон. Уг судалгаа нь Google forms-оор авсан бөгөөд 6 хаалттай асуулт боловсруулан сурагчдын нийгмийн сүлжээнд тохиолдож буй гадуурхалт, зөв зохисгүй байдалд хэрхэн хандаж буйг судалсан байна.

Та хэддүгээр ангийн сурагч вэ?


53 хариулт



Энэхүү хариултуудаас харвал бидний авч буй судалгааг дунд ангийнхан буюу голчлон 8, 9 дүгээр ангийнхан бөглөсөн байна.

Facebook платформыг хэдэн наснаас эхлэн ашиглах нь зүйтэй вэ?


18 / 53 зөв хариулт



Дээрх асуулгыг нийт судалгаанд хамрагдсан 53 сурагчдын 18 нь буюу 34% зөв хариулсан нь сурагчдын платформын талаар мэдлэг хомс байгааг илтгэж байна. Энэхүү асуулт сурагчдыг хууль эрх зүйн үүднээс фейсбүүк хэрэглэж эхлэх боломжтой насыг мэдэж байгаа үгүйг олж тогтоох зорилготой байв. Монгол улсын хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид 6 ба түүнээс дээш анги, 12-оос дээш насны хүүхэд Фейсбүүк ашиглах эрх зүйн хэмжээнд очдог байна.

Та Facebook платформыг хэдэн наснаас эхлэн ашигласан бэ?


53 хариулт



Судалгаанд хамрагдсан сурагчдын 36 нь буюу 67,9% facebook платформын орчинд орох боломжтой эрх зүйн насанд хүрэхээсээ өмнө энэхүү цахим сүлжээнд оролцож, ашиглаж иржээ. Ингээд харвал эрх зүйн боломжит насанд хүрээгүй хүүхдүүд цахим орчинд багагүй байдаг байна. Үүний нэг шалтгаан нь дижитал шилжилт өргөн цар хүрээтэйгээр хурдтай байгаа бол нөгөөтэйгүүр насанд хүрэгчид буюу эрх зүйн хариуцлагатай асран хамгаалагчид бага насны хүүхдүүдэд хараа хяналтыг зохистой тавьж чадахгүй байна гэж үзэж болно.

Та цахим орчинд бусдын гаргасан ямар зохисгүй үйлдлүүдийг харж байсан бэ?


53 хариулт



Энэхүү асуултад нийт судалгаанд хамрагсдын 77,4% болох 41 нь цахим орчинд “Бүдүүлэг үг хэллэг, бусдын нэр төрд халдах” гэх зохисгүй үйлдлийг цахим орчинд харж байжээ. Харин үүний дараагаар 23 нь буюу 43,4% “Гадуурхалт, дээрэлхэлт”, “Хууран мэхлэлт, хулгай” гэхийг харсан байна. Үүнээс үзвэл ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын цахим орчин дахь гадуурхалтын асуудал нь цахим орчны зохисгүй байдал, кибер аюулд хоёрт жагсдаг хэмээн харж болно.

### Цахим гадуурхалт/ дээрэлхэлтээс хэрхэн сэргийлэх нь зөв бэ?


25 / 53 зөв хариулт



Цахим орчин дахь гадуурхалтаас хэрхэн сэргийлэх талаар асуултад судалгаа бөглөсөн 53 хүүхдээс 25 буюу 47,2% нь зөв хариулснаас үзвэл 11-15 насны хүүхдүүд болох дунд ангийн сурагчдын мэдлэг, ойлголт гүйцэт зөв биш байна. “Хувийн мэдээллээ задруулахгүй байх” нь хамгийн зөв арга гэж үзсэнээс бусад хариултуудтай жишин харвал өсвөр насны хүүхдүүд дунд “хамгаалалт тавих, хянах” ойлголт дутуу байна хэмээн харж болно.

### Хэрвээ та цахим гадуурхалтанд өртөх аль эсвэл өртсөн хүнийг харвал ямар арга хэмжээг түрүүлж авах ёстой вэ?

29 / 51 зөв хариулт



Дээрх асуулгыг 51 бөглөгсдөөс 29 буюу 56,9% зөв хариулснаас харвал ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын талаас илүү хувь нь гадуурхалтад өртөх тохиолдолд ямар арга хэмжээ авах ёстойг мэддэг гэж үзэж болно. Гэвч “Тэвчих, үл тоох” гэдэг хариулт байсаар байгааг харвал буруу ойлголтыг зарим хүүхдүүд тээж байна. “Дээрэлхэгчтэй хамт хохирогчийг шоглох” сонголтод тодорхой хэмжээнд хариу байхыг үзвэл сурагчид дунд гадуурхалттай хэрхэн тэмцэх талаарх зохисгүй ойлголт тархалттай байна хэмээн үзэв.

**Судалгааны хоёрдугаар хэсэг:** Энэ хэсэгт бид “Наран ерөнхий боловсролын сургууль”-н сурагчидтай ярилцаж, Facebook платформ дээр тандсан бөгөөд сурагчидтай ярилцаж, асуулга авахдаа 3 сэдвийг сонгон авсан. Үүнд:

1. Facebook хэр удаан ашиглаж байгаа талаар
2. Өмнө нь цахим гадуурхалтад өртөж байсан үгүй талаар
3. Өртөж байсан бол хэрхэн? Яаж нөлөөлсөн?

Энэхүү асуулгад нийт 10 сурагч оролцсоны үндсэн дээр 6-9р ангийн сурагчид ихэвчлэн буюу 7сурагч 3-4 жил Facebook платформд бүртгэлтэй байсан. 10 сурагчаас 8 буюу 80% нь цахим гадуурхалтад өртөж байсан бөгөөд давтамжтайгаар 6 сурагч болох 60% өртөж байсан байна. Цахим гадуурхалт нь тэрхүү сурагчдын гадаад төрхөөс голцуу үүддэг гэсэн бөгөөд тухайн сурагчдын зан араншин эсрэг тэсрэг болоход шууд нөлөөлсөн гэв.

**Санал зөвлөмж:** “Сонгож төрөөгүй төрхийнхөө төлөө сонгосон газартаа гадуурхагдаж, зохисгүй үйлдэлд хамрагдах нь эрх тэгш байдал биш юм. Бусдын төлөө дугарах, бусдад үл хайхрах хандлага гаргахгүй байх нь харин эрх тэгш байдлыг бүтээдэг. Зөвхөн сурагч бидний хийх ажил энэ биш болно. Ерөнхий боловсролын сургуулиудын багш, нийгмийн ажилтан нар сурагчдад сурган зөвлөх, асран хамгаалагчид хүүхдүүдтэй ярилцах хэрэгтэй асуудал.

Сурагч багачууд юуг хэрхэн хийж байгаагаа ухамсарлах чадвар төдийлөн их байдаггүй учир дунд ангийн сурагчид дунд гадуурхалт ихээр гардаг. Харин цахим шилжилт хийгдэж, цахим сүлжээ хөгжиж эхэлснээр тэрхүү гадуурхалт цахим орчин руу шилжин орсон. Эрх зүйн чадвартай болж амжаагүй хүүхдүүдийн сэтгэлзүйн байдал төдийлөн хүчтэй биш учир бид хойч үедээ анхаарал тавьж, цахим орчны зохистой байдлыг талаарх мэдлэгийг тараан өргөжүүлэх бага залуу насныханд чиглэсэн үйл ажиллагаа идэвхтэй хийх нь зүйтэй.”

### Дүгнэлт

Цахим сүлжээ нь эрчимтэй хөгжиж буй дэлхий дахины сүлжээ аж. Энэхүү эрчийг гүйцэж чадахгүй байгаа зарим хүн төрөлхтний хэсэг нь хүүхэд багачууд бид болно. Цахим шилжилт хийгдэх тусам соёл, зохистой зан гэх ойлголтууд өөрчлөгдөн хувьсаж байгаа бөгөөд өсвөр насны нийгэмд дөнгөж хөл тавьж буй сурагчид энэ талаар мэдлэг дутуу дулимаг үлдсээр байна. Цахим орчны зохисгүй хэрэглээнээс үүдэн гарч ирдэг хор уршгийн нэг нь яалт ч үгүй гадуурхалт юм. Гадуурхалт нь төлөвшиж амжаагүй хүүхдүүдэд сөргөөр ихээхэн нөлөөлдөг ба энэ нь цаашлаад бие физиологи, сэтгэлзүйн хувьд өвчлөл үүсгэх аюултай. Тэгвэл цахим гадуурхалт нь бидний судалснаар дотроо олон хуваагддаг байна.

Үүнд:

1. Бусдын нэр төрд халдсан үйл ажиллагаа цахим орчинд явуулах
2. Худал хуурмаг, сөрөг мэдээг хэн нэгэн рүү чиглүүлэн цахим орчинд тараах
3. Бусдын хувийн нууцлалд халдсан үйлдэл цахим орчинд гаргах
4. Бусдыг ямар нэг байдлаар хохироох санаатай болоод санаандгүй үйлдэл цахим орчинд гаргах
5. Цахим орчинд бусдад дайсагнан сүрдүүлэх

хэмээн хуваагддаг байна. Тэгвэл цахим гадуурхалтаас сэргийлэх, тухайн үед авах арга хэмжээ ч бас өөр өөр байдаг ба энэ нь:

1. Тухайн платформ дээр Report хийх
2. Сошиал орчинд холбосон төхөөрөмжүүддээ тодорхой хамгаалалт тавих
3. Хувийн нууц, мэдээллээ бусдад задруулахгүй байх
4. Өөрийн цахим блог дээрх үйл ажиллагаанд хяналт тавих

гэх аргууд байдаг байна.

Ашигласан материал

1. [www.1212.mn](http://www.1212.mn) Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
2. <https://criminal.police.gov.mn> Эрүүгийн цагдаагийн алба
3. <https://legalinfo.mn/mn/detail/6163> Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
4. <https://napoleoncat.com> Олон улсын нийтийн сүлжээний судалгааны байгууллага
5. <https://gia.gov.mn> Монгол улсын тагнуулын ерөнхий газар